



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/04/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа

Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	17
4. Менежментийн захидал .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021. 02.05 № 02  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН СЭЛЭНГЭ ГОЛЫН  
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА  
М.ЧУЛУУНЗАГД ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

D:\my doc \albanbichig\ 2019-A4.doc

**Аудитын гол асуудал:**

1. Үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тушаалаар 4 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт 2,867.4 мянган төгрөгийг 12 сарын цалинтай хамт, 409787 тоот төлбөрийн хүсэлтийн дагуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн "Эдийн засгийн ангилал" батлах тухай 55 дугаар тушаалын "210101-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин, 210102-Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд, тухайлбал онцгой нөхцөлийн, ажилласан хугацааны, зэрэг дэвийн, мэргэжлийн зэргийн, ур чадварын, дэвтэр зассан, анги удирдсан, цолны цалин гэх мэт үндсэн цалингаас хувиар бодож буюу үнэмлэхүй хэмжээгээр тогтоон олгож байгаа нэмэгдлүүд багтана" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тайлант онд тус байгууллага үндсэн данснаас 6,687.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 12,154.3 мянган төгрөг, нийт 18,841.8 мянган төгрөгийн тээвэр шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн спидометрийн заалт ажилладаггүй гэсэн шалтгааны улмаас жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийж, хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна. 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, тохилдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байх тул шатахууны зардлыг хязгаарлаж байна.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>35,922,010.00</u></b>	<b><u>36,853,684.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,149,110.00	2,210,864.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,149,110.00	2,210,864.00
3351	Байгууллагаас авах авлага	2,149,110.00	2,210,864.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	33,772,900.00	34,642,820.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	33,547,900.00	33,547,900.00
35110	Тусгай зориулалттай материал	33,547,900.00	33,547,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	225,000.00	1,094,920.00
35410	Бичиг хэргийн материал	225,000.00	1,094,920.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>9,147,416.59</u></b>	<b><u>5,616,239.57</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	9,147,416.59	5,616,239.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	9,147,416.59	5,616,239.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	00.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	24,290,250.00	24,459,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,822,176.86	-22,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,107,320.00	27,107,320.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,240,653.28	-25,607,320.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,559,370.84	6,559,370.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,746,694.11	-4,402,631.27
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>45,069,426.59</u></b>	<b><u>42,469,923.57</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>45,069,426.59</u></b>	<b><u>42,469,923.57</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	45,069,426.59	42,469,923.57
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	45,069,426.59	42,469,923.57
51210	Өмнөх үеийн үр дүн	45,069,426.59	45,069,426.59
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-2,599,503.02
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>45,069,426.59</u></b>	<b><u>42,469,923.57</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>179,277,547.00</b>	<b>246,263,186.00</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>649,975.00</b>	<b>2,259,500.00</b>
Нийтлэг татварын бус орлого	649,975.00	2,259,500.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	649,975.00	2,259,500.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	300,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	449,975.00	1,959,500.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>178,627,572.00</b>	<b>244,003,686.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>149,099,000.00</b>	<b>176,289,400.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	149,099,000.00	176,289,400.00
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,528,572.00</b>	<b>67,714,286.00</b>
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,528,572.00	52,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	714,286.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,000,000.00
Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>189,166,008.69</b>	<b>248,862,689.02</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>189,166,008.69</b>	<b>248,862,689.02</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>162,901,163.69</b>	<b>218,054,432.96</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>83,822,605.00</b>	<b>94,860,277.00</b>
Үндсэн цалин	71,015,031.00	68,173,600.00
Нэмэгдэл	8,093,474.00	14,616,576.53
Унаа хоолны хөнгөлөлт	4,714,100.00	5,629,359.47
Урамшуулал	00.00	6,440,741.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,631,000.00</b>	<b>12,611,415.64</b>
Тэтгэврийн даатгал	7,188,609.00	8,687,515.64
Тэтгэмжийн даатгал	868,872.00	981,000.00
ҮОМШӨ-ний даатгал	679,505.00	784,800.00
Ажилгүйдлийн даатгал	169,800.00	196,100.00
Эрүүл мэндийн даатгал	1,724,214.00	1,962,000.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,376,400.00</b>	<b>11,504,400.00</b>
Гэрэл, цахилгаан	297,650.00	362,400.00
Түлш, халаалт	00.00	00.00
Цэвэр, бохир ус	00.00	00.00
Байрны түрээс	11,078,750.00	11,142,000.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,086,547.00</b>	<b>40,458,973.30</b>
Бичиг хэрэг	2,474,796.00	9,826,780.00
Тээвэр, шатахуун	19,908,761.00	28,821,786.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,068,010.00	1,236,207.30
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	634,980.00	574,200.00
<b>Нормативт зардал</b>	<b>759,994.00</b>	<b>00.00</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	759,994.00	00.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,988,400.00</b>	<b>4,063,200.00</b>
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	178,200.00
Урсгал засвар	1,988,400.00	3,885,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,937,100.00</b>	<b>3,382,800.00</b>
Дотоод албан томилолт	6,937,100.00	3,382,800.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,028,750.00</b>	<b>10,082,690.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,469,300.00	9,565,200.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	00.00
Даатгалын үйлчилгээ	158,400.00	00.00
Тээврийн хэрэгслийн татвар	34,750.00	201,490.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	66,000.00

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	250,000.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,270,367.69</b>	<b>41,090,677.02</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	709,500.00	32,185,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,851,000.00	3,415,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,709,867.69	5,490,677.02
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,264,845.00</b>	<b>30,808,256.06</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,810,500.00</b>	<b>21,392,900.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,810,500.00	21,392,900.00
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>454,345.00</b>	<b>9,415,356.06</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг	454,345.00	9,415,356.06
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-9,888,461.69</b>	<b>-2,599,503.02</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-9,888,461.69</b>	<b>-2,599,503.02</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>81,999,800.00</b>	<b>244,303,686.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>200,000.00</b>	<b>300,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	200,000.00	300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	300,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	300,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>81,799,800.00</b>	<b>244,003,686.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	61,699,800.00	176,289,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	61,699,800.00	176,289,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	20,100,000.00	67,714,286.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,100,000.00	52,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	714,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	15,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>76,651,547.00</b>	<b>244,303,686.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>76,651,547.00</b>	<b>244,303,686.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>76,651,547.00</b>	<b>213,495,429.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	40,307,450.00	94,860,277.00
210101	Үндсэн цалин	32,433,718.00	68,173,600.00
210102	Нэмэгдэл	5,028,132.00	21,057,317.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,845,600.00	5,629,359.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,201,707.00	12,611,415.64
210201	Тэтгэврийн даатгал	3,543,724.00	8,687,515.64
210202	Тэтгэмжийн даатгал	429,170.00	981,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	327,743.00	784,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	81,861.00	196,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	819,209.00	1,962,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,346,350.00	11,504,400.00
210301	Гэрэл, цахилгаан	136,350.00	408,500.00
210302	Түлш, халаалт	00.00	205,800.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	297,100.00
210304	Байрны түрээс	4,210,000.00	10,593,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,818,890.00	41,390,647.30
210401	Бичиг хэрэг	1,423,300.00	10,696,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,548,000.00	28,821,786.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	485,890.00	1,297,961.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	361,700.00	574,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,194,800.00	4,063,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	178,200.00
210604	Урсгал засвар	1,194,800.00	3,885,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,952,200.00	3,382,800.00
210702	Дотоод албан томилолт	2,952,200.00	3,382,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,647,150.00	10,082,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,285,700.00	9,565,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	158,400.00	160,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,750.00	40,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,183,000.00	35,600,000.00

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	343,000.00	32,185,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,840,000.00	3,415,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>30,808,256.06</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	21,392,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	21,392,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	00.00	9,415,356.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,415,356.06
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5,348,253.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	5,348,253.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	5,348,253.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	71,806,143.92	71,806,143.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>71,806,143.92</b>	71,806,143.92
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-16,848,255.64	-16,848,255.64
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>45,069,426.59</b>	45,069,426.59
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>45,069,426.59</b>	45,069,426.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>45,069,426.59</b>	45,069,426.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-2,599,503.02	-2,599,503.02
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>42,469,923.57</b>	42,469,923.57

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	176,289,400.00	167,174,043.94
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	176,289,400.00	167,174,043.94
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	154,896,500.00	145,781,143.94
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	98,100,100.00	94,860,277.00
210101	Үндсэн цалин	68,173,600.00	68,173,600.00
210102	Нэмэгдэл	24,177,200.00	21,057,317.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,749,300.00	5,629,359.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,203,300.00	12,611,415.64
210201	Тэтгэврийн даатгал	9,279,400.00	8,687,515.64
210202	Тэтгэмжийн даатгал	981,000.00	981,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	784,800.00	784,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	196,100.00	196,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,962,000.00	1,962,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,512,200.00	11,504,400.00
210301	Гэрэл, цахилгаан	416,300.00	408,500.00
210302	Түлш, халаалт	205,800.00	205,800.00
210303	Цэвэр, бохир ус	297,100.00	297,100.00
210304	Байрны түрээс	10,593,000.00	10,593,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,597,600.00	9,183,361.30
210401	Бичиг хэрэг	623,700.00	623,700.00
210402	Тээвэр, шатахуун	6,687,500.00	6,687,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,482,700.00	1,297,961.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	803,700.00	574,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	356,400.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	356,400.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,718,200.00	1,743,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	178,200.00
210604	Урсгал засвар	4,540,000.00	1,565,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,172,500.00	2,550,800.00
210702	Дотоод албан томилолт	3,172,500.00	2,550,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,816,300.00	9,912,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,396,900.00	9,395,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	545,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	351,900.00	160,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,500.00	40,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3419900.00	3415000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,419,900.00	3,415,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	21392900.00	21392900.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	21,392,900.00	21,392,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,392,900.00	21,392,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	176,289,400.00	167,174,043.94
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	176,289,400.00	167,174,043.94
131001	Улсын төсвөөс санхүүжих	176,289,400.00	167,174,043.94

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7-р зүйлийн 7.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны дарга М.Чулуунзагд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 28 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Өнөө болон ирээдүй үеийнхний
- Сайн сайхан амьдралын төлөө
- Үзэсгэлэнт сайхан Сэлэнгэ мөрнөө
- Үе хойчдоо өвлүүлэн үлдээх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 114,582.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,145.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлого 246,263.2 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул 1 хувиар буюу 2,462.6 мянган төгрөг болгон өөрчилсөн.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,599.5 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,149.10	2,149.10	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	33,547.90	34,642.82	1,094.92
Үндсэн хөрөнгө	9,147.40	5,616.23	-3,531.17
Нийт хөрөнгө	45,069.40	42,469.90	-2,599.50
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	-	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	45,069.40	42,469.90	-2,599.50

Авлага дансны үлдэгдэл 2,149.1 мянган төгрөг байсан нь тайлант онд барагдаагүй нь насжилт ихтэй татаас санхүүжилтийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ аваагүйгээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2016 онд үүссэн, он удаан жил болсон Байгал орчин аялал жуулчлалын яамнаас авах татаас санхүүжилтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл мянган төгрөг болж 1,094.9 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын дансны үлдэгдлээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,531.2 мянган төгрөгөөр буурч 5,616.23 мянган төгрөг болсон нь тайлант онд 1,790.25 мянган төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн мотоциклийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 599 тогтоолын дагуу данс бүртгэлээс хасаж, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,959.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргаанд 2020 оны санхүүгийн тайланд биет бус хөрөнгө, өр төлбөр дансанд урт болон богино хугацаат өр төлбөр бүртгэгдээгүй.

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 66,985.6 мянган төгрөгөөр буюу 37 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал санхүүжилтийн орлого бөгөөд өмнөх оноос 27,190.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 176,289.4 мянган төгрөг болсон бол нэмэлт санхүүжилтийн орлого 37,471.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 67,000.0 мянган төгрөг болсон байна.

Нийт зардал өмнөх оноос 50,343.1 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин 11,037.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 1,980.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 16,434.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 25,820.3 мянган төгрөгөөр тус тус зардлууд өссөн байна. Энэ нь 2020 онд Байгаль орчны яам болон бусад аймгийн сав газрын захиргаануудын уулзалт Орхон аймагт зохион байгуулагдсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 201,531.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 201,531.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25,241.9 мянган төгрөгөөр бууруулж 176,289.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд бараа үйлчилгээний зардлыг 29,568.0 мянган байхаар тусгасан боловч 26,148.1 мянган төгрөгөөр хасаж 3,419.9 мянган төгрөгөөр баталсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 176,289.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 176,289.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 176,289.4 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 167,174.0 мянган төгрөгийг зарцуулж 9,115.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 176,289.4 мянган төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 3,239.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 414.2 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 2,975.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 903.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 52,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 300.0 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 714.3 мянган төгрөг,

Байгаль орчны газраас сургалт, хяналт шалгалтын ажилд 15,000.0 мянган төгрөг нийт 68,014.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалд 32,207.3 мянга, эд хогшил худалдан авахад 2,320.0 мянга, томилолт, зочны зардалд 832.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 32,185.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 170.0 мянга, нийт 67,714.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 300.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Сав газруудын талуудын оролцооны зөвлөл, сав газрын захиргааны зөвлөгөөн Орхон аймагт зохион байгуулагдахтай холбоотойгоор Засаг даргын 2020 оны А/254 тоот захирамжаар 50,000.0 мянган төгрөгийг шийдэж өгсөн.

Уг ажлыг зохион байгуулахад бусад аймгаас ирэх байгууллагын буцах шатахууны зардалд 9,980.0 мянган төгрөг, аймаг дотор үйлчлэх шатахуунд 800.0 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 7,630.0 мянган төгрөг, аймагт байрлах буудлын хөлсөнд 9,900.0 мянган төгрөг, аймагт байрлах хоолны зардал 7,500.0 мянган төгрөг, хээр байрлах хоолны зардалд 14,190.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг хэрэгжүүлээгүй үрэлгэн зарцуулсан байна

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 113 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 34 мэдээлэл, 0 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.10-р зүйлд заасны дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлгийг хийж мэдээлээгүй. Мөн байгууллагын даргын тушаалаар төсөв, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбогдон гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй. Хуулийн 6.4.5 заалтын дагуу 5.0 сая төгрөгөөс дээш дүн бүхийн орлого зарлагын гүйлгээнд 4 сараас хойш санхүүжилтийн орлогыг мэдээлээгүй байхад аудитын явцад залруулга хийлгэж нөхөж мэдээлүүлсэн.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмжийн хэрэгжилт бүртгэгдээгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 205,233.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 131,375.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 21,709.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 52,149.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж хүргүүлэв.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайланд нэмэлт санхүүжилтийн данснаас авсан 34,722.3 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар авсан орлогоор бүртгэснийг залруулсан.

2. Холбооны газраас ирүүлсэн тулган баталгаажуулалтын захидлаар 61.6 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй байсныг залруулсан.
3. Үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 9,415.4 мянган төгрөгийг орлогоос бууруулах бичилт хийснийг залруулсан.
4. Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулаагүй дутуу мэдээлсэн 87,176.1 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг нөхөж мэдээлж залруулсан.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 73,858.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 21,709.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Тус байгууллага нь 2020 оны үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22 тоот тушаалаар 4 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт 3,600.0 мянган төгрөгийг бодож, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ суутгаж 2,867.4 мянган төгрөгийг 12 сарын цалинтай хамт 409787 тоот төлбөрийн хүсэлтийн дагуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн “Эдийн засгийн ангилал” батлах тухай 55 дугаар тушаалын “210101-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин, 210102-Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд, тухайлбал онцгой нөхцөлийн, ажилласан хугацааны, зэрэг дэвийн, мэргэжлийн зэргийн, ур чадварын, дэвтэр зассан, анги удирдсан, цолны цалин гэх мэт үндсэн цалингаас хувиар бодож буюу үнэмлэхүй хэмжээгээр тогтоон олгож байгаа нэмэгдлүүд багтана” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд тус байгууллага үндсэн данснаас 6,687.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 12,154.3 мянган төгрөг нийт 18,841.8 мянган төгрөгийн тээвэр шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн спидометрийн заалт ажилладаггүй гэсэн шалтгааны улмаас жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийж, хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна. 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, тохилдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 52,149.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны шатахуун зарцуулалтын анхан шатны баримт авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Сав газруудын талуудын оролцооны зөвлөл, сав газрын захиргааны зөвлөгөөн Орхон аймагт зохион байгуулагдахтай холбоотойгоор Засаг даргын 2020 оны А/254 тоот захирамжаар 50,000.0 мянган төгрөгийг шийдэж өгсөн. Уг ажлыг зохион байгуулахад бусад аймгаас ирэх байгууллагын буцах шатахууны зардалд 9,980.0 мянган төгрөг, аймаг дотор үйлчлэх шатахуунд 800.0 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 7,630.0 мянган төгрөг, аймагт байрлах буудлын хөлсөнд 9,900.0 мянган төгрөг, аймагт байрлах хоолны зардал 7,500.0 мянган төгрөг, хээр байрлах хоолны зардалд 14,190.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, үрэлгэн зарцуулсан байна.

**1.2 Эрсдэл:** хувийн ашиг сонирхол үүсэх, ашиглал бий болох

**1.3 Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хангаж анхан шатны нотлох баримтыг иж бүрэн бүрдүүлж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж байх.

**1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 35 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

##### **2.Балансын данстай холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** 2016 онд бүртгэгдсэн 2,149.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.

**2.2. Эрсдэл:** Насжилт ихтэй авлага бий болох, авлага барагдахгүй байх.

**2.3. Өгсөн зөвлөмж:** Авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 35 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

##### **3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:** Төсвийн тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагад жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн ирүүлэхдээ Сангийн сайдын 388-р тушаал заасны дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайланг огт бэлтгэж тайлагнаагүй.

**3.2. Эрсдэл:** Мэдээлэл хэрэглэгчид буруу мэдээлэл авах.

**3.3. Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 388-р тушаалд заасны дагуу тодруулга тайланг үнэн зөв, иж бүрэн бэлтгэн тайлагнаж байх.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2021 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 35 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Аудитор

Т.БОЛОРМАА

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Б.ЭРДЭНЭ

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор

Ц.НАРМАНДАХ



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ОРА-2021/4/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргаа</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22 тоот тушаалаар 4 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт 3,600.0 мянган төгрөгийг 12 сарын цалинтай хамт 409787 тоот төлбөрийн хүсэлтийн дагуу олгосон.	2,867.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	М.Чулуунзагд, Б.Дариймаа
2	Тайлант онд тус байгууллага үндсэн данснаас 6,687.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 22,134.3 мянган төгрөг нийт 28,821.8 мянган төгрөгийн тээвэр шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн спидометрийн заалт ажилладаггүй гэсэн шалтгааны улмаас жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийж, хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан	18,841.8	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	М.Чулуунзагд, Б.Дариймаа
3	Сав газруудын талуудын оролцооны зөвлөл, сав газрын захиргааны зөвлөгөөн Орхон аймагт зохион байгуулагдахтай холбоотойгоор Засаг даргын 2020 оны А/254 тоот захирамжаар 50,000.0 мянган төгрөгийг шийдэж өгсөн. Уг ажлыг зохион байгуулахад бусад аймгаас ирэх байгууллагын буцах шатахууны зардалд 9,980.0 мянган төгрөг, аймаг дотор үйлчлэх шатахуунд 800.0 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 7,630.0 мянган төгрөг, аймагт байрлах буудлын хөлсөнд 9,900.0 мянган төгрөг, аймагт байрлах хоолны зардал 7,500.0 мянган төгрөг, хээр байрлах хоолны зардалд 14,190.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу, үрэлгэн зарцуулсан байна.	50,000.0	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Чулуунзагд, Б.Дариймаа

Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	2016 онд бүртгэгдсэн 2,149.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүйгээс байна.	2,149.1	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Чулуунзагд, Б.Дариймаа
5	Төсвийн тухай хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагад жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн ирүүлэхдээ Сангийн сайдын 388-р тушаал заасны дагуу санхүүгийн тайлангийн тодруулга тайланг огт бэлтгэж тайлагнаагүй.		Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	М.Чулуунзагд, Б.Дариймаа
<b>ДҮН</b>		<b>73,858.3</b>			

Гурав. Баталгаажуулалт:

Тайлан бэлтгэсэн:

Аудитор

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Аудитын менежер

Хоёр дах шатны чанарын хяналт хийсэн:

Дарга, тэргүүлэх аудитор



Т.БОЛОРМАА

Б.ЭРДЭНЭ

Ц.НАРМАНДАХ



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 01/01.2021/04/СТА-ТШЗ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2020 оны үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 22 дугаар тушаалаар 4 ажилтанд түлээ нүүрсний хөнгөлөлт 3,600.0 мянган төгрөгийг бодож, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ суутгаж, 2,867.4 мянган төгрөгийг 12 сарын цалинтай хамт, 409787 тоот төлбөрийн хүсэлтээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн "Эдийн засгийн ангилал" батлах тухай 55 дугаар тушаалын "210101-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин, 210102-Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалинууд, тухайлбал онцгой нөхцөлийн, ажилласан хугацааны, зэрэг дэвийн, мэргэжлийн зэргийн, ур чадварын, дэвтэр зассан, анги удирдсан, цолны цалин гэх мэт үндсэн цалингаас хувиар бодож буюу үнэмлэхүй хэмжээгээр тогтоон олгож байгаа нэмэгдлүүд багтана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргаа нь үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас түлээ нүүрсний хөнгөлөлт 2,867.4 мянган төгрөгийг

олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны дарга М.Чулуунзагд, нягтлан бодогч Б.Дариймаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР  
..... Т.БОЛОРМАА

<sup>1</sup> Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 02/02 ОМ-2021/04/СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сэлэнгэ голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд тус байгууллага үндсэн данснаас 6,687.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 12,154.3 мянган төгрөг нийт 18,841.8 мянган төгрөгийн тээвэр шатахууныг зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн спидометрийн заалт ажилладаггүй гэсэн шалтгааны улмаас жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийж, хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д " Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тээвэр шатахуунд 18,841.8 мянган төгрөгийг зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, жолоочийн тооцооны хуудсыг иж бүрэн хийж, хянаж баталгаажуулдаггүй, байгууллагад бүртгэлээр тавих хяналт алдагдсан зөрчлийг

арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Сэлэнгэ голын сав газрын захиргааны дарга М.Чулуунзагд, нягтлан бодогч Б.Дариймаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮЙДЭХ  
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... Т.БОЛОРМАА

<sup>1</sup> Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757